МОНГОЛ УЛСЫН
# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 05 өдөр Дугаар 431 Улаанбаатар хот

Хорт хавдрын бүртгэл-тандалтын журам
батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.14, Засгийн газрын 2014 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёрдахь хөтөлбөр”-ийн 3.4.3, 5.2 заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Хорт хавдрын бүртгэл-тандалтын журмыг 1 дүгээр, нэр томъёоны тодорхойлолт, тайлбарыг 2 дугаар, хорт хавдрын бүртгэл-тандалтын маягт болон бүртгэх зааврыг 3 дугаар, хавдрын эрт илрүүлэг, бүртгэл-тандалт хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү тушаалыг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж, хорт хавдрын эрт илрүүлэг, бүртгэл-тандалтын тогтолцооны дэд бүтцийг оновчтой зохион байгуулж, шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэж байхыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Хорт хавдрын өвчлөл, хорт хавдраар өвчилсөн хүний хяналт, хөнгөвчлөх эмчилгээ, хорт хавдрын шалтгаант нас бараалттай холбоотой мэдээллийг цуглуулах, дамжуулах, нэгтгэн, эргэн мэдээлэх, дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээ авах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, хорт хавдраас урьдчилан сэргийлэх, хянахад мэргэжил арга зүй, удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төв (Л.Төмөрбаатар)-д даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хорт хавдрыг бүртгэх удирдамж”-ийг хүчингүй болсонд тооцсугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал)-т даалгасугай.

САЙД Н.УДВАЛ

022510

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12
сарын 05 өдрийн 431 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

# ХОРТ ХАВДРЫН БҮРТГЭЛ-ТАНДАЛТЫН ЖУРАМ

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Хорт хавдрын бүртгэл-тандалтын тогтолцоо /цаашид бүртгэл-тандалтын тогтолцоо гэнэ/ гэдэг нь үндэсний хэмжээнд хорт хавдрын шинэ өвчлөл, хорт хавдрын улмаас эмчийн хяналтад байгаа хүний талаарх болон хорт хавдрын шалтгаант нас бараалттай холбоотой мэдээг тогтмол цуглуулах, нэгтгэх, дамжуулах, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх, хорт хавдраас урьдчилан сэргийлэх, хянах үйл ажиллагааг төлөвлөхөд мэдээллээр хангах, нотолгоонд тулгуурласан хариу арга хэмжээ авах цогц үйл ажиллагааг хэлнэ.

1.2. Бүртгэл-тандалтыг хүн амд суурилсан хэлбэрээр зохион байгуулна.

1.3. Бүртгэл-тандалтаар Монгол улсын харьяат хүн амын дунд тохиолдсон хорт хавдартай холбоотой бүх мэдээг цуглуулна. Гадаадын харъяат иргэдийн хорт хавдрын өвчлөл, нас баралтын талаарх мэдээг цуглуулахгүй.

1.4. Бүртгэл-тандалтын тогтолцоо нь байран өмөн (in situ), анхдагч байрлалын хорт хавдар, лимфома, лейкеми, анхдагч байрлал тодорхойгүй хорт хавдрын үсэрхийлэлтэй холбоотой мэдээг цуглуулна.

1.5. Бүртгэл-тандалтын мэдээнд эмнэлэгт суурилсан идэвхгүй тандалт болон идэвхтэй хайлтын тандалтаар хорт хавдрын шинэ тохиолдол, хорт хавдраар өвчилсөн хүний амьд эсэхийг магадалсан, хорт хавдрын шалтгаант нас баралтын тохиолдол, хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдсан хүний мэдээ, байрлал өвөрмөц хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдээ багтана.

1.6. Бүртгэл-тандалтын тогтолцооны үйл ажиллагаанд “Өвчний олон улсын X ангилал-Хавдар судлал-III” болон “Хортой хавдрын TNM ангилал” гарын авлагыг ашиглана.

1.7. Дараах эрүүл мэндийн болон эрүүл мэндийн бус байгууллагууд бүртгэл-тандалтын тогтолцооны мэдээний эх сурвалж байгууллагууд байна:

Эрүүл мэндийн байгууллагууд:

- Аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг;
- Нийгмийн эрүүл мэндийн төв;
- Бүсийн оношилгоо эмчилгээний төв;
- Хавдар судлалын үндэсний төв;
- Улсын нэгдүгээр төв эмнэлэг;
- Улсын хоёрдугаар төв эмнэлэг;

- П.Н. Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг;
- Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв;
- Арьсны өвчин судлалын үндэсний төв;
- Гэмтэл, согог судлалын үндэсний төв;
- Халдварт өвчин судлалын үндэсний төв;
- Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төв;
- Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв;
- Геронтологийн үндэсний төв;
- Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг;
- Улаанбаатар Төмөр замын Нэгдсэн эмнэлэг;
- Эмгэг судлалын үндэсний төв;
- Хувийн эмнэлгүүд;
- Хувийн лабораториуд;
- Хосписууд;
- Хавдар судлалын үндэсний төвийн хөх, умайн хүзүүний эргэн дуудах, эрт илрүүлэх үзлэгийн тогтолцооны мэдээ.

Эрүүл мэндийн бус байгууллагууд:

- Улсын бүртгэлийн ерөнхий газар-иргэний бүртгэлийн газар;
- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн-Шүүх эмнэлгийн хэлтэс;
- Эрүүл мэндийн даатгалын байгууллагууд.

1.8. Бүртгэл-тандалтын тогтолцооны мэдээний санд хорт хавдрын өвчлөл, хорт хавдартай өвчтөний хяналтын мэдээ, хөнгөвчлөх эмчилгээний мэдээ, хорт хавдрын шалтгаант нас баралт, байрлал өвөрмөц хорт хавдрын бүртгэлийн мэдээний сан тус тус багтана.

1.9. Бүртгэл-тандалтын тогтолцоонд хорт хавдрын өвчлөлийн түвшин, хорт хавдрын тархалтын түвшин, хорт хавдрын эмчилгээний хувь, хорт хавдрыг баталсан шинжилгээний хувь, хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдсан хүний тоо, хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, байрлал өвөрмөц хорт хавдрын эрсдлийн мэдээлэл зэрэг үндсэн үзүүлэлтийг тооцож оруулна.

1.10. Бүртгэл-тандалтын тогтолцоонд эрүүл мэндийн төрийн захиргааны төв байгууллагын хүлээн зөвшөөрсөн программ хангамжийг ашиглана.

1.11. Бүртгэл-тандалтын тогтолцооны цуглуулсан мэдээ нь хувь хүний нууцын тухай хууль болон бусад холбогдох заавар журмын дагуу хамгаалагдана.

1.12. Төр, хувийн хэвшлийн бүх эрүүл мэндийн байгууллагууд бүртгэл-тандалтын тогтолцоотой холбогдох хууль, тогтоомж, тушаал, журам, стандартыг дагаж мөрдөнө.

## ХОЁР. МЭДЭЭНИЙ ТӨРӨЛ

2.1. Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлын мэдээг дараах төрлүүдээр цуглуулна:

- Хорт хавдрын шинэ тохиолдлыг оношилсон тохиолдол бүрд улсын болон хувийн хэвшлийн тухайн эрүүл мэндийн байгууллага “Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ5 маягт”-аар Хавдар судлалын үндэсний төвд улирал тутам мэдээлнэ.

- Хорт хавдрын шинэ тохиолдлыг оношилсон лаборатори “Хорт хавдрыг эмгэг судлалын лабораториос мэдээлэх хуудас АМ-5-ЭС маягт”-аар Хавдар судлалын үндэсний төвд улирал тутам мэдээлнэ.

- Эрүүл мэндийн байгууллагуудад оношлогдсон хорт хавдрын шинэ тохиолдлыг илрүүлэх идэвхтэй хайлтын тандалтад эрүүл мэндийн байгууллагын амбулатори болон станционарын бүртгэлийн дор дурдсан мэдээний сан ба маягтыг ашиглана:

  Өвчний түүх: СТ-1А, 1Б;

  Эмчийн үзлэгийн бүртгэл: АМ-1А, 1Б;

  Лабораторийн шинжилгээний хуудсууд АМ-22;

  Лабораторийн шинжилгээний бүртгэл АМ-23;

  Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдагсдын бүртгэл АМ-26А, АМ-26Б;

  Шүүх эмнэлгийн задлан шинжилгээний бүртгэл ШЭ-2, ШЭ-3, ШЭ-9;

  Эмгэг судлалын шинжилгээний протокол, илгээлт: ЭС-1, ЭС-3).

2.2. “Хорт хавдраар өвчилсөн хүний амьд эсэхийг магадалсан мэдээ”-г хавдар судлаач эмч хорт хавдрын хяналтын өвчтөн тус бүрээр гаргаж, хорт хавдрын эрт илрүүлэг,бүртгэл-тандалтын мэргэжилтэнд болон Хавдар судлалын үндэсний төвд жилийн эцэст мэдээлнэ.

2.3. Эрүүл мэндийн байгууллагууд хорт хавдрын шалтгаант нас баралтын тохиолдлын мэдээг “Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ7 маягт”-аар бүртгэж, Хавдар судлалын үндэсний төвд улирал тутам мэдээлнэ.

2.4. Эрүүл мэндийн байгууллагууд хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдсан хүний тоон мэдээг Хавдар судлалын үндэсний төвд улирал тутам мэдээлнэ.

2.5. Эрүүл мэндийн байгууллагууд хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийг бүртгэх хуудсыг бөглөж, АМ-5 маягтанд хавсарган Хавдар судлалын үндэсний төвд улирал тутам мэдээлнэ.

## ГУРАВ: МЭДЭЭНИЙ ЭХ СУРВАЛЖ БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ, МЭДЭЭНИЙ УРСГАЛ

### 3.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн үүрэг

- Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн эмч харъяа нутаг дэвсгэрийнхээ хүн амаас оношлогдсон хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, эмчлэгдэж байгаа хүн, хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийг бүртгэх хуудас, хорт хавдрын улмаас нас барсан тохиолдлыг тусгай журналд болон холбогдох маягтын дагуу бүртгэж, харъяалах удирдлагаар хянаж баталгаажуулан аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн хорт хавдрын эрт илрүүлэг, бүртгэл-тандалтын мэргэжилтэнд цаасан болон цахим хэлбэрээр сар бүр мэдээлнэ.

- Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдсан хүний тоон мэдээг тусгай журналд бүртгэж, энэхүү журмын 3 дугаар хавсралтын тавдугаар хуудасны дагуу бүртгэж, харъяалах удирдлагаар хянаж баталгаажуулан аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн хорт хавдрын эрт илрүүлэг, бүртгэл-тандалтын мэргэжилтэнд цаасан болон цахим хэлбэрээр улирал бүрийн сүүлийн өдөр мэдээлнэ.

- Хорт хавдрын бүртгэл-тандалтын ажлын уялдаа холбоог сайжруулах, тулгамдсан асуудлаа тогтоож, шийдвэрлэх зорилгоор холбогдох эмч, сувилагч, статистикчдын уулзалтыг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг жил бүрийн 10 дугаар сард зохион байгуулна.

### 3.2. Аймаг, нийслэлийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, НЭМТ, Эрүүл мэндийн газрын үүрэг

- Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг оношилсон Нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн эмч хорт хавдрыг мэдээлэх хуудас болон хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийг бүртгэх хуудас, нас барсан тохиолдолд “Нас барсан эмнэлгийн гэрчилгээний маягт”-ыг тус тус хөтлөн, тусгай журналд бүртгэж, харъяалах удирдлагаар хянаж баталгаажуулан аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн хорт хавдрын эрт илрүүлэг, бүртгэл-тандалтын мэргэжилтэнд тухай бүр нь мэдээлнэ.

- Аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн хорт хавдрын эрт илрүүлэг, бүртгэл-тандалтын мэргэжилтэн хорт хавдрын бүртгэл-тандалтын мэдээний давхардлыг шалган нэгтгэж, мэдээний сан үүсгэн хавдар судлаач эмч, харъяалах удирдлагаар хянуулж, баталгаажуулна.
- Аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлгийн хавдар судлаач эмч энэхүү журмын 1 дүгээр хавсралтын хүснэгт 4-д заасан үзүүлэлтүүдийн дагуу аймаг, дүүргийн хорт хавдрын эрт илрүүлэг, бүртгэл-тандалтын мэргэжилтэний нэгтгэсэн мэдээ, мэдээллийн чанар, үнэн зөв байдалд хяналт тавьж, баталгаажуулан

улирал бүрийн мэдээг  дараа улирлын эхний сарын 10-нд багтаан цаасан болон цахим хэлбэрээр  ХСҮТ-д илгээнэ.

- Аймаг, дүүргийн ЭМГ-ын статистикч эмч Нийгмийн эрүүл мэндийн төвийн хорт хавдрын эрт илрүүлэг, бүртгэл-тандалтын мэргэжилтэний хорт хавдрын бүртгэл- тандалтын мэдээний хагас, бүтэн жилийн нэгтгэл, тайланд энэхүү журмын 1 дүгээр хавсралтын хүснэгт 4-д заасан үзүүлэлтүүдийн дагуу хяналт тавьж, харъяалах удирдлагаар хянуулж баталгаажуулан Хавдар судлалын үндэсний төвд мэдээлнэ.
- Аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн хорт хавдрын эрт илрүүлэг, бүртгэл-тандалтын мэргэжилтэн нь хорт хавдрын хяналтын бүртгэлээс алдагдсан, шилжилт хөдөлгөөн тодорхойгүй хүний мэдээллийг өөрийн аймаг, дүүргийн иргэний бүртгэлийн хэлтсийн мэдээний санд байгаа мэдээлэлтэй тулгалт хийн тодруулж, жилийн эцэст Хавдар судлалын үндэсний төвд мэдээлнэ.
- Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар хорт хавдрын бүртгэл-тандалтын чанар, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, бүртгэл-тандалтын уялдаа, давхардлыг арилгах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хорт хавдраас урьдчилан сэргийлэх, хянах, тандах үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах зорилгоор оролцогч бүх байгууллагуудын эмч, мэргэжилтний нэгдсэн уулзалтыг жил бүрийн 11 дүгээр сард зохион байгуулна.
- Бүртгэл-тандалтын тогтолцоог хэрэгжүүлж байгаа харъяалах байгууллагуудын үйл ажиллагаанд жил бүр дэмжлэгт хяналт зохион байгуулж, удирдлага,  арга зүйн зөвлөмжөөр ханган,  байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангаж,  тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэнэ.
- Үндэсний хэмжээнд шийдвэрлэх асуудлын талаар Хавдар судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн яаманд жил бүр мэдээлнэ.

### 3.3. Төв болон тусгай мэргэжлийн эмнэлэг, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үүрэг

- Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг оношилсон эмч хорт хавдрыг мэдээлэх хуудас болон хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийг бүртгэх хуудас,  нас барсан тохиолдолд нас барсан эмнэлгийн гэрчилгээний маягтыг тус тус бүртгэж, статистикч их эмчид мэдээг тухай бүр нь мэдээлнэ.
- Статистикч их эмч  эрүүл мэндийн байгууллагын хорт хавдрын өвчлөл, нас баралтыг батлагдсан маягтын дагуу программд оруулж, Хавдар судлалын үндэсний төвд дараа улирлын эхний сарын 10-нд цаасан болон цахим хэлбэрээр  мэдээлнэ.

### 3.4. Эмгэг судлалын үндэсний төв, улсын болон хувийн хэвшлийн лабораторийн үүрэг

- Тухайн лабораторид оношлогдсон хорт хавдрын шинэ тохиолдол бүрийг хорт хавдрыг лабораториос мэдээлэх хуудас маягтаар бүртгэж, Хавдар судлалын үндэсний төвд дараа улирлын эхний сарын 10-нд мэдээлнэ.

3.**5. Хавдар судлалын үндэсний төвийн үүрэг**

- Тус төв нь хорт хавдрын бүртгэл-тандалтын улсын хэмжээний мэдээг цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх, мэдээний чанарын хяналтыг сайжруулах, програм хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангах, хариу арга хэмжээ авах, нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, ажлыг зохион байгуулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- Бүртгэл-тандалтын тогтолцооны үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.
- Бүртгэл-тандалтын тогтолцооны мэдээнд дүн шинжилгээ хийж, хорт хавдрын өвчлөл, нас баралтын жилийн тайланг Эрүүл мэндийн хөгжлийн төвд жилийн эцэст мэдээлнэ.
- Бүртгэл-тандалтын тогтолцооны мэдээллийг боловсруулан "Хорт хавдрын өвчлөл, нас баралтын үзүүлэлт" эмхтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэл хэвлүүлэх, Хавдар судлалын үндэсний төвийн цахим хуудсанд байршуулах зэргээр шууд, шаардлагатай бол шууд бус удирдлагын байгууллагуудад түгээнэ.
- Бүртгэл-тандалтын тайланг "Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр"-ийн Удирдах хорооны хурлаар жил бүр хэлэлцүүлнэ.
- Бүртгэл-тандалтын тогтолцооны хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх зорилгоор улирал бүрийн сүүлийн сарын дөрөв дэх долоон хоногт холбогдох байгуулагуудтай цахим хурал зохион байгуулж мэргэжил арга зүйгээр хангана.
- Бүртгэл-тандалтын тогтолцооны үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийнэ.
- Бүртгэл-тандалтын тогтолцооны удирдамж болон програм хангамжийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангана.
- Бүртгэл-тандалтын тогтолцооны чиглэлээр эмч, мэргэжилтнүүдийн давтан сургалтыг холбогдох бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

3.6 **Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үүрэг**

- Хавдар судлалын үндэсний төвөөс хорт хавдрын бүртгэл-тандалтын тогтолцооны мэдээг мэдээний урсгалын дагуу хүлээн авч, "Эрүүл мэндийн үзүүлэлт" эмхтгэлд оруулна.
- Бүртгэл-тандалтын чанарыг сайжруулахад мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.
- Бүртгэл-тандалтын тогтолцоонд "Хорт хавдрын өвчлөл, нас баралтын үндэсний хэмжээний мэдээний сан"-г ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.
- Эмч, мэргэжилтнүүдийн давтан сургалтыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

**-oOo-**

**Зураг 1: Хорт хавдрын бүртгэл-тандалтын тогтолцооны мэдээний урсгал**



## ДӨРӨВ. МЭДЭЭНИЙ САН

4.1. Хорт хавдрын өвчлөлийн мэдээний санг “Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ5, “Хорт хавдрыг лабораториос мэдээлэх хуудас АМ5-ЭС” маягтын дагуу бүрдүүлнэ.

**Хүснэгт 1. Хорт хавдрын өвчлөлийн мэдээний сангийн агуулга**

| Өвчтний хэсэг | Хавдрын хэсэг | Эмчилгээний хэсэг |
|---|---|---|
| Эцэг эхийн нэр | Хорт хавдар оношлогдсон он, сар, өдөр | Хийгдсэн эмчилгээний төрөл |
| Өөрийн нэр | Хорт хавдар оношлогдсон газар | Хийгдсэн мэс заслын код |
| Регистрийн дугаар | Бүртгэлийн байдал | Мэс засал хийгдсэн газар |
| Төрсөн он, сар, өдөр | Хорт хавдрыг оношилсон шинжилгээний төрөл | |
| Нас | Анхдагч хорт хавдрын байрлал (ӨОУА-ХС-3) | |
| Хүйс | T / N / M үе шат | |
| Мэргэжлийн код | Эмнэл зүйн үе шат | |
| Ажил эрхлэлтийн байдал | Анхдагч хорт хавдрын бүтэц зүйн онош (ӨОУА-ХС-3) | |
| Албан тушаал | Хорт хавдрын эсийн төлөв | |
| Боловсрол | Хорт хавдрын эсийн ялгарал | |
| Оршин суугаа газар | Анхдагч олон байрлалын хорт хавдар мөн эсэх | |
| Гэрлэлтийн байдал | Хос эрхтэн эсэх | |
| Амьд эсэх | Шинжилгээ хийсэн лабораторийн нэр | |
| | Лабораторийн шинжилгээний дугаар | |
| | Мэдээлсэн эмчийн нэр | |
| | Мэдээлсэн он, сар, өдөр | |

4.2. Хорт хавдартай өвчтөний “Хяналтын мэдээний цахим сан” нь хяналтын өвчтөн тус бүрийн эмчилгээ болон амьд эсэхийг магадалсан мэдээг багтаасан байна.

4.3 Хөнгөвчлөх эмчилгээний мэдээний сан нь хөнгөвчлөх тусламжид хамрагдсан хүний тоо болон хөнгөвчлөх тусламж үзүүлдэг мэргэжилтний тоо, өвдөлт намдаах эмийн талаарх мэдээг багтаасан байна.

4.4 Хорт хавдрын шалтгаант нас баралтын мэдээний санг “Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ7 маягт”-ын дагуу бүрдүүлнэ.

**Хүснэгт 2. Хорт хавдрын нас баралтын мэдээний сангийн агуулга**

| Өвчтний хэсэг | Нас баралтын мэдээлэл |
|---|---|
| Эцэг эхийн нэр | Нас барсан он, сар, өдөр |
| Өөрийн нэр | Нас барсан газар |
| Регистрийн дугаар | Нас барсан хэлбэр |
| Төрсөн он, сар, өдөр | Үхэлд хүргэсэн шууд шалтгаан |
| Нас | Үхлийн үндсэн шалтгааны код |
| Хүйс | Хорт хавдар оношлогдсоноос хойш амьдарсан хугацаа |
| Мэргэжилийн код | Гэрчилгээ олгосон он, сар, өдөр |
| Ажил,албан тушаал | Эмчлэгч эмч |
| Боловсрол | Гэрчилгээ олгосон эмч |
| Тогтмол хаяг | |

4.5. Байрлал өвөрмөц хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийн мэдээний сан нь хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийн бүртгэлийн хуудасны дагуу бүрдэнэ.

4.6. Мэдээний сангийн аюулгүй байдал ба хадгалах хугацаа:

- Хорт хавдрын бүртгэл-тандалтын тогтолцооны нэгдсэн мэдээний цахим санг сар, улирал, жилээр үүсгэж хадгална.
- Мэдээний сангийн мэдээллийг зөөврийн хатуу диск болон өөр серверт давхар хадгалж аюулгүй байдлыг хангана.
- Мэдээний санг холбогдох журмын дагуу хадгална.

## ТАВ. ХОРТ ХАВДРЫН БҮРТГЭЛ-ТАНДАЛТЫН ТАЙЛАН БА ҮЗҮҮЛЭЛТ

Хавдар судлалын үндэсний төв нь бүртгэл-тандалтын тогтолцооны үзүүлэлтийг тооцон дараах тайланг гаргаж жил бүр түгээнэ.

**Хүснэгт 3. Бүртгэл-тандалтын тогтолцооны тайлан**

| Тайлангийн төрөл | Тооцох үзүүлэлт |
|---|---|
| "Шинээр оношлогдсон хорт хавдрын өвчлөлийн тайлан" ЭМТ 303.1 | 1. Хорт хавдрын насаар өвөрмөц өвчлөлийн түвшин (100,000 хүн амд)<br>2. Хорт хавдрын өвчлөлийн түвшин (100,000 хүн амд)<br>3. Хорт хавдрын өвчлөлийн стандартчилсан түвшин (100,000 хүн амд) |
| "Шинээр оношлогдсон хорт хавдрын өвчлөлийн эмчилгээний тайлан" ЭМТ 303.3 | 1. Хорт хавдрын эмчилгээний хувь |
| "Шинээр оношлогдсон хорт хавдрын өвчлөлийн оношилгоо, шинжилгээний тайлан" ЭМТ 303.5 | 1. Хорт хавдрын онош баталсан шинжилгээний хувь |
| Хөнгөвчлөх эмчилгээний тайлан | 1. Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдсан хүний тоо, хувь<br>2. Өвдөлт намдаах эмчилгээний үзүүлэлт<br>3. Сургалт хамрагдсан (ар гэр, асран хамгаалагч) хүний тоо<br>4. Шинээр нэмэгдсэн орны тоо<br>5. Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо |
| "Хорт хавдрын шалтгаант нас баралтын тайлан" ЭМТ 303.2 | 1. Хорт хавдрын нас баралтын насаар өвөрмөц түвшин (100,000 хүн амд)<br>2. Хорт хавдрын нас баралтын түвшин (100,000 хүн амд)<br>3. Хорт хавдрын нас баралтын стандартчилсан түвшин |
| "Хорт хавдрын хяналтын тайлан" ЭМТ 303. 4 | 1. Хорт хавдартай өвчтөний тархалтын түвшин (100, 000 хүн амд)<br>2. Хорт хавдраар өвчлөгсдийн ажиглалтын жилүүдэд амьдарсан хувь |
| Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийн тайлан | Эрсдэлт хүчин зүйлсийн үзүүлэлт |

## ЗУРГАА. МЭДЭЭНИЙ ЧАНАРЫН ХЯНАЛТ

Хавдар судлалын үндэсний төв нь бүртгэл-тандалтын тогтолцооны мэдээний чанарыг дараах нийтлэг болон өвөрмөц үзүүлэлтээр тооцож үнэлнэ. Чанарын үнэлгээг жил бүр хийнэ.

**Хүснэгт 4. Чанарын үзүүлэлтүүд**

| Үзүүлэлт | Тодорхойлолт / тайлбар / тооцох аргачлал |
|---|---|
| Мэдээний үнэн зөв байдал | Маягтын дагуу мэдээг үнэн зөв мэдээлэх байдал |
| Мэдээний бүрэн байдал | Тухайн аймаг, дүүргийн нийт өвчлөл, нас баралтыг бүрэн хамарч байгаа эсэх |
| Харьцуулахуйц, хэмжигдэхүйц байх | Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ангиллуудыг ашиглаж байгаа эсэх |
| Бодитой байх | Тайлант хугацаанд мэдээлсэн тоон үзүүлэлт болон мэдээний нэгтгэлийг бүртгэлийн маягттай дахин тулгах, нягтлах<br><br>Хэрэв зөрөө байвал шалтгааныг тогтоох |
| Мэдээ цаг хугацаандаа байх | Тогтоосон цаг хугацаанд мэдээлж байгаа эсэх |
| Нас баралтын гэрчилгээгээр бүртгэгдсэн шинэ тохиолдлын хувь (НБГ % ) | Нийт хорт хавдрын шинэ тохиолдлын дотор нас баралтын гэрчилгээгээр бүртгэгдсэн хорт хавдрын шинэ тохиолдлын эзлэх хувь |
| Хорт хавдрын нас баралт, өвчлөлийн харьцаа (НБ/Ө харьцаа), | Хорт хавдрын өвчлөл ба нас баралтын түвшинг харьцуулж гаргах үзүүлэлт |
| Эдийн шинжилгээгээр батлагдсан хувь (М/Б %) | Нийт хорт хавдрыг оношилсон шинжилгээний дунд эд эсийн шинжилгээний эзлэх хувь |
| Анхдагч байрлал тодорхойгүй ба нас тодорхойгүй тохиолдлын хувь | Анхдагч байрлал тодорхойгүй хорт хавдрын шинэ тохиолдлын эзлэх хувь ба нас тодорхойгүй тохиолдлын эзлэх хувь |

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
12 сарын 05 өдрийн 431 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

## ХОРТ ХАВДРЫН БҮРТГЭЛ-ТАНДАЛТЫН ТОГТОЛЦООНД ХЭРЭГЛЭГДЭХ НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ, ТАЙЛБАР

1. ***Хүн амд суурилсан бүртгэл -*** тухайн орон нутгийн нийт хүн амын дунд тохиолдсон хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлын бүртгэл;

2. ***Байран өмөн -*** суурин мембраныг нэвтэлж ургаагүй үеийн хорт хавдар;

3. ***Анхдагч байрлалын хорт хавдар -*** анх уг эрхтэн эдэд үүссэн нь нотлогдож оношлогдсон тохиолдол;

4. ***Анхдагч байрлал тодорхойгүй үсэрхийлэл -*** анхдагч байрлал нь тодорхойгүй харин үсэрхийлэл нь оношлогдсон тохиолдол;

5. ***Идэвхтэй хайлтын*** *тандалт* - эрүүл мэндийн болон эрүүл мэндийн бус байгууллагын холбогдох мэдээний сан болон бүртгэлийн маягт, журнал зэрэг баримтыг ашиглан хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг идэвхтэй тандалтын аргаар олж, илрүүлж мэдээлэх үйл ажиллагаа;

6. ***Өвчний олон улсын ангилал "Хавдар судлал – 3"*** - Хавдар судлалын практикт тохиолдох бүхий л өвчлөлийг тодорхой шалгуурын дагуу ангилан бүлэглэсэн тогтолцоо бөгөөд бичгээр илэрхийлсэн хорт хавдрын оношийг үсэг тоогоор илэрхийлэх кодонд шилжүүлснээр мэдээг хадгалах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх ажлыг хялбаршуулсан хэлбэр юм. Энэхүү ангилал нь Өвчний олон улсын Х ангиллаас салбарласан ангилал бөгөөд бүртгэл тандалтын тогтолцоонд хэрэглэгдэнэ.

7. ***Хортой хавдрын TNM ангилал -*** хорт хавдрын хэмжээ, ойролцоох тунгалагийн булчирхай болон алсын үсэрхийллийг илтгэж хорт хавдрын үе шатыг тогтоох гол түлхүүр ангилал;

8. ***Мэдээний эх сурвалж -*** хорт хавдрын бүртгэл тандалтын тогтолцоонд мэдээ өгч байгаа бүхий л байгууллагууд;

9. ***Мэдээний сан -***холбогдох маягт, үнэлгээний хуудас, мэдээний хуудсаар цугларсан мэдээг нэгтгэн үүсгэсэн сан;

10. ***Хорт хавдрын эрт илрүүлэг, бүртэл тандалт хариуцсан мэргэжилтэн -*** аймаг дүүрэгт ажиллаж байгаа хорт хавдрын бүртгэл-тандалтын тогтолцооны анхдагч нэгжийн хорт хавдартай холбоотой бүхий л мэдээ мэдээллийг хариуцах ажилтан;

11. ***Хорт хавдрын өвчлөл -*** тухайн хүн амын дунд хуанлийн нэг жилийн дотор хорт хавдраар шинээр өвчилсөн тохиолдлын бодит тоо;

12. ***Хорт хавдрын нас баралт -*** тухайн хүн амын дунд хуанлийн нэг жилийн дотор хорт хавдрын улмаас нас барсан тохиолдлын бодит тоо;

13. ***Хорт хавдрын тархалт -*** өмнөх оны хяналтад амьд үлдсэн хүний тоо ба тухайн жилийн шинээр хорт хавдраар өвчилсөн хүний нийлбэр;

14. ***Хорт хавдрын өвчлөлийн түвшин -*** тухайн жилийн 100,000 хүн ам тутамд ногдох хорт хавдрын шинэ тохиолдлын тоо бөгөөд нийт өвчлөлийг 100, 000 хүн амд үржүүлж, нийт хүн амын тоонд харьцуулсан үзүүлэлт;

15. ***Хорт хавдрын нас баралтын түвшин -*** тухайн жилийн 100,000 хүн ам тутамд ногдох хорт хавдрын нас баралтын тохиолдлын тоо бөгөөд нийт нас баралтыг 100, 000 хүн амд үржүүлж, нийт хүн амын тоонд харьцуулсан үзүүлэлт;

16. ***Хорт хавдрын тархалтын түвшин -*** тухайн жилийн 100,000 хүн ам тутамд ногдох хорт хавдрын тархалтын тохиолдлын тоо бөгөөд нийт тархалтыг 100, 000 хүн ам үржүүлж, нийт хүн амын тоонд харьцуулсан үзүүлэлт;

17. ***Хорт хавдрын насаар өвөрмөц өвчлөлийн түвшин -*** тухайн жилийн 5 насаар бүлэглэсэн насны бүлэг тутмын 100,000 хүн ам тутамд ногдох хорт хавдрын шинэ тохиолдлын тоо бөгөөд тухайн насны бүлгийн өвчлөлийг 100, 000 хүн амд үржүүлж, тухайн насны бүлгийн хүн амын тоонд харьцуулсан үзүүлэлт;

18. ***Хорт хавдрын нас баралтын насаар өвөрмөц түвшин -*** тухайн жилийн 5 насаар бүлэглэсэн насны бүлэг тутмын 100,000 хүн ам тутамд ногдох хорт хавдрын нас баралтын тохиолдлын тоо бөгөөд тухайн насны бүлгийн нас баралтыг 100, 000 хүн амд үржүүлж, тухайн насны бүлгийн хүн амын тоонд харьцуулсан үзүүлэлт;

19. ***Хорт хавдрын өвчлөлийн стандартчилсан түвшин -*** энэхүү үзүүлэлтийг тооцсоноор өөр цаг хугацаа болон өөр нутаг орны хорт хавдрын өвчлөлийг харьцуулах боломжтой болно. Насны бүлэг тус бүрийн насаар өвөрмөц өвчлөлийн түвшинг тухайн насны дэлхийн стандарт хүн амд харьцуулж, нийлбэрийг 100,000 хүн амд харьцуулж гарсан үзүүлэлт;

19. ***Хорт хавдрын нас баралтын стандартчилсан түвшин -*** насны бүлэг тус бүрийн насаар өвөрмөц нас баралтын түвшинг тухайн насны дэлхийн стандарт хүн амд харьцуулж, нийлбэрийг 100,000 хүн амд харьцуулж гарсан үзүүлэлт;

20. ***Хорт хавдраар өвчлөгсдийн ажиглалтын жилүүдэд амьдарсан хувь -*** ажиглалтын 1, 3, 5 жилүүдийн төгсгөлд хяналт, ажиглалтад байгаа хүний хэдэн хувь нь амьдарч байгааг тооцдог үзүүлэлт.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12
сарын 05 өдрийн 431 дугаар тушаалын
3 дугаар хавсралт

# ХОРТ ХАВДРЫН БҮРТГЭЛ- ТАНДАЛТЫН МЭДЭЭЛЭХ ХУУДАС, ХӨТЛӨХ ЗААВАРЧИЛГА

## 1. ХОРТ ХАВДРЫГ МЭДЭЭЛЭХ ХУУДАС

| | | | |
|---|---|---|---|
| Эмнэлгийн нэр, лого | РД | | |
| | Тохиолдлын дугаар: | | |
| **Бүртгэлийн байдал:** | Эрт илрүүлэг | | Идэвхтэй хайлт |
| **Эцэг, эхийн нэр:** | **Өөрийн нэр:** | | |
| Төрсөн он сар өдөр / / | 4. Нас [ ]<br>**5.** Хүйс:<br>☐ Эрэгтэй<br>☐ Эмэгтэй | **Ажлын газар, албан тушаал**<br><br>**Мэргэжил:** | |

| | | |
|---|---|---|
| **Тогтмол хаяг:**<br>Аймаг/хот:____________________<br>Сум/дүүрэг: _____________________<br>Баг/хороо:______________________<br>Гудамж/Байшин: ________ Тоот<br>Утас: ______________ | **Боловсрол:**<br>☐ Бага ☐ Дээд<br>☐ Дунд ☐Боловсролгүй<br>☐ Мэргэжлийн-техникийн | **Гэр бүлийн байдал:**<br>☐ Гэрлээгүй<br>☐ Гэр бүлтэй<br>☐ Тодорхойгүй |

| | |
|---|---|
| **Хавдар оношлогдсон огноо:**<br>он сар өдөр | **Өвчтөний одоогийн байдал:**<br>☐ Амьд – 1 ☐ Нас барсан -2<br>☐ Тодорхойгүй - 3 |

| | |
|---|---|
| **Анхдагч хавдрын байрлалын онош:** | С_____/___ |
| **Бүтэц зүйн онош** | М______/__ |

**Хорт хавдар TNM үе шатны ангиллаар:** T – is, 1, 2, 3, 4, X N – 0, 1, 2, 3, X M – 0, 1, X

**Хавдрын төлөв:** ☐ Байран өмөн – 2 ☐ Хортой – 3 ☐ Үсэрхийлсэн - 6

| | |
|---|---|
| **Эсийн ялгарал:**<br>☐ Өндөр ялгаралтай-1 ☐ Бага ялгаралтай-3<br>☐ Дунд ялгаралтай-2 ☐ Ялгаралгүй-4<br>☐ Ялгарлын зэрэг тодорхойгүй-9 | **Лимфома, лейкемийн эсийн ялгарал:**<br>☐ Т-эсийн – 5, ☐ В-эсийн /pre-B,B-precursor/ -6<br>☐ Null эсийн / non-T, non-B/ -7 ☐ Киллер эсийн /natural/-8, ☐ эсийн төрөл тодорхойгүй-9 |

| **Анхдагч олон байрлалын хавдар мөн эсэх:** | **Хос эрхтнийг хамарсан эсэх:** |
|---|---|
| ☐ Анхдагч ганц байрлалын хавдар-1<br>☐ Анхдагч олон байрлалын хавдрын нэг тохиолдол-2<br>☐ Тодорхойгүй-9 | ☐ Баруун-1 ☐ Зүүн-2<br>☐ 1 талыг хамарсан боловч ялгаж тусгаагүй-3<br>☐ Хоёр талын хамарсан-4<br>☐ Хос эрхтэн бус-5 |
| **Бичил харуурын бус** | **Бичил харуурын** |
| ☐ 1- Нас баралтын гэрчилгээгээр<br>☐ 2- Эмнэл зүйн бүрдэл шинжээр<br>☐ 3- Дүрс оношилгоо /КТГ, дуран, рентген, ЭХО, MRI, оношлогооны лапротоми ................/ аль нь болохыг доогуур нь зурж өөрчлөлт, хэмжээг тавих<br>☐ 4-Лабораторийн оношлуур /цус, хавдрын өвөрмөц маркер, иммунологи........../ аль нь болохыг доогуур нь зурж өөрчлөлт, хэмжээг тавих | ☐ 5-Эсийн шинжилгээ<br>☐ 6-Эдийн шинжилгээ үсэрхийлсэн эдээс /задлан шинжилгээний эд хамаарна/<br>☐ 7 - Эдийн шинжилгээ анхдагч эдээс /задлан шинжилгээний эд, ясны эд хамаарна/<br>☐ 8- Мэдэхгүй |

**Хавдрын эмнэл зүйн үе шат: I, II, III, IV ба үүнээс өөрөөр бичигдэх бол:________________**

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хийгдсэн эмчилгээ | Мэс засал | 1 | Хими+даавар эмчилгээ | 8 |
| | Туяа | 2 | Дархлаа дэмжих эмчилгээ | 9 |
| | Хими | 3 | Даавар эмчилгээ | 10 |
| | Мэс засал+туяа | 4 | Хөнгөвчлөх мэс засал | 11 |
| | Мэс засал+хими | 5 | Бусад хөнгөвлөх эмчилгээ, тусламж | 12 |
| | Туяа+хими+мэс засал | 6 | | |
| | Хими+туяа | 7 | Эмчилгээнээс татгалзсан | 14 |

| | |
|---|---|
| Хийгдсэн мэс заслын нэр /Үйлдлийн ОУ-9 ангилалаар тавих, кодлох/ | Онош ҮОУА-9 |
| Мэс засал хийгдсэн эмнэлэг | |
| Холбоо барих утас: ___________________ | Мэдээлсэн огноо: он сар өдөр |

| | | | |
|---|---|---|---|
| Тамга | Мэдээлсэн эмч: | | |
| | Албан тушаал | Нэр | Гарын үсэг |

## 2. Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5 маягтыг хөтлөх зааварчилга

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11 сарын 27-ны өдрийн 450 дугаар тушаалаар хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг "Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5 маягт" батлагдсан. АМ-5 маягтыг дорхи хүснэгтэд бичигдсэн аргачилал, жишээг ашиглан хөтөлнө.

| Маягтын асуумж | Аргачлал-Тодорхойлолт - Жишээ |
|---|---|
| Эмнэлгийн нэр, лого | АМ5 маягтыг хөтөлж байгаа эмнэлгийн нэр, лого бүхий хэвлэмэл маягт байна |
| Бүртгэлийн байдал | Эрт илрүүлэг, Идэвхтэй хайлтаар хорт хавдар оношлогдсон тохиолдолд аль тохирохыг сонгон *√ * тэмдэг тавина |
| **I. Хувь хүний тухай мэдээлэл** | |
| Өвчтөний регистрийн дугаар (РД): | Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ.<br><br>**Анхаарах зүйл:** РД гэсэн 10 нүд бүхий хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр дармалаар, сүүлийн 8 нүдэнд цифрийг нүд тус бүрт гаргацтай тод бичнэ.<br><br>Жишээ нь:<br><br>А \| Ю \| 7 \| 8 \| 1 \| 2 \| 2 \| 9 \| 1 \| 3 |
| Өвчтөний эцэг, эхийн болон өөрийн нэр | Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн тод гаргацтай, татлахгүйгээр үнэн зөв бичнэ |
| Төрсөн он, сар, өдөр | Төрсөн он, сар, өдрийг бичихдээ өвчтөний иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн бичнэ .<br><br>Жишээ нь: 1978/12/29<br><br>**Анхаарах зүйл:** Төрсний гэрчилгээ аваагүй бол төрөлтийн түүхэн дэх төрсөн он, сар, өдрийг бичнэ. Төрсөн он сарыг мэдэх боломжгүй тохиолдолд оныг мэдэж байвал сар өдрийг 01 сарын 01-ээр авна. |
| Өвчтөний нас | "Нас" гэсэн нүд бүхий хүснэгтэд насыг бичихдээ төрсөн он, сарыг үндэслэн насыг тооцоолж бичнэ. Жишээ нь: насыг тооцоход 3 настай гэж гарсан бол<br><br>003<br><br>гэж бичнэ. Хэрэв сар болон хоногтой бол нэгжийн оронг 0 |

| | |
|---|---|
| | болгож хүснэгтийн гадна сар, хоног аль нь болохыг бичнэ.<br><br>**Анхаарах зүйл**: Өвчтөний насыг мэдэх боломжгүй, нотлох бичиг баримт огт байхгүй бол хорт хавдрын онош тавигдсан он, сар өдрөөр тооцоолно. |
| Хүйс | Эрэгтэй, Эмэгтэй аль нь болохыг сонгон *√ * тэмдэг тавина. |
| Ажлын газар, албан тушаал | Өвчтөний хорт хавдрын онош батлагдах үед хийж гүйцэтгэж байгаа ажлын газар, албан тушаалыг дэлгэрэнгүй бичнэ.<br><br>Ажлын газар,албан тушаалын кодыг Эрүүл мэндийн сайдын 450 дугаар тушаалаар батлагдсан маягт бүртгэлийн эмхтгэл номын Хүснэгт №3-ийг ашиглана.<br><br>Жишээ нь: Боловсролын салбарт ажилладаг албан хаагч бол<br><br>\| 1 \| 6 \| 0 \| 2 \|<br><br>гэж бичнэ.<br><br>**Анхааруулга:** Ажлын газаргүй буюу аль нэг кодод ороогүй ажлын газар бол 22-ыг сонгоно. |
| Мэргэжил | Өвчтөний амьдралынхаа ихэнх хугацаанд ажиллаж өнгөрүүлсэн болон тухайн мэргэжлээр нарийвчлан сурч ажилласан мэргэжлийг бичнэ. Харгалзах 2 нүдэнд доорхи кодуудаас сонгон бичнэ. Эрүүл мэндийн сайдын 34 дугаар тушаалаар батлагдсан маягт бүртгэлийн эмхтгэл номын Хүснэгт №4-ийг ашиглана.<br><br>Жишээ: мэргэжил багш бол<br><br>\| 0 \| 4 \|<br><br>гэж бичнэ. |
| Боловсрол | Боловсрол бага -1 /дунд сургуулийн 1- 4-р ангийг төгссөн /<br><br>Боловсрол дунд-2 /дунд сургуулийн 5-11-р ангийг төгссөн/<br><br>Боловсрол мэргэжлийн-3 / Мэргэжлийн болон техникийн коллеж төгссөн/<br><br>Боловсрол дээд-4 /Их дээд сургууль төгссөн/<br><br>Боловсролгүй -5 /ямар нэгэн сургууль төгсөөгүй буюу сургуульд ороогүйг хамааруулна/ |
| Гэр бүлийн байдал | Гэрлээгүй, гэр бүлтэй, тодорхойгүй аль болохыг сонгон *√ * |

| | |
|---|---|
| | тэмдэглэгээ хийнэ. |
| Одоогийн оршин суугаа хаяг | Өвчтөний иргэний үнэмлэхийг үндэслэн аймаг, хот, сум, дүүрэг, хороо, хаалганы дугаар зэргийг гаргацтай тод бичнэ. Харгалзах 6 нүд бүхий хүснэгтэнд Эрүүл мэндийн сайдын 34 дугаар тушаалаар батлагдсан маягт бүртгэлийн эмхтгэл номын Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ангилал Хүснэгт №1-ийг ашиглан кодыг сонгон эхний 2 нүдэнд аймаг, хотын, дунд 2 нүдэнд сум, дүүргийн, сүүлийн 2 нүдэнд баг, хорооны кодыг бичнэ.<br>Жишээ: Хөвсгөл аймгийн рашаант сум 1-р хороо гэсэн бол<br>1 \| 7 \| 1 \| 1 \| 0 \| 1<br>бичнэ. |
| **II. Хорт хавдрын мэдээлэл** | |
| Хавдар оношлогдсон огноо | Хавдрыг оношилсон шинжилгээ ба бусад үндэслэлийн дагуу хавдрын онош батлагдсан хамгийн эхний он, сар, өдрийг тооцон тавина. |
| Өвчтөний одоогийн байдал | Хорт хавдар оношлогдох үед тухайн хүний байдал<br>Амьд-1, Нас барсан-2, Тодорхойгүй-3 –ийн аль тохирохыг сонгон дугуйлна. |
| Анхдагч хавдрын байрлалын онош | Хүний биеийн эрхтэн системийн аль хэсэгт хавдар байрлаж байгааг тодорхой заасан оношийг дэлгэрэнгүй бичнэ. Өөрөөр хэлбэл, Өвчний олон улсын X ангиллын 2-р бүлгийг ашиглан анхдагч хавдрын байрлалын оношийг бичмэлээр болон кодоор тавина. |
| Олон улсын өвчний Хангилал-хавдар судлал-III | "Олон улсын өвчний X ангилал-Хавдар судлал-III" гарын авлагыг ашиглана. Жишээ нь: ходоодны их биеийн хэсгийг хамарсан хорт хавдар С16.3 гэж кодлоно. Өвчний олон улсын X ангилал - Хавдар судлал-III цусны хорт хавдрын /лейкеми/ -С42 |
| Морфологийн онош /бүтэц зүйн / | Эд, эсийн шинжилгээний дүгнэлтээс хавдрын эсийн төрөл, төлөв байдлыг дэлгэрэнгүй бичиж, ОУӨАХС-III гарын авлагыг ашиглан кодлоно. Жишээ нь: Аденокарцинома ӨЗГ бол М8140 гэж кодлоно |
| Оношлогдох үеийн хавдрын үе шат / Олон улсын TNM ангилалыг баримтлан тавина/ | **Т- нь анхдагч хавдрын хэмжээ /тархалт/**<br>T-is Байран өмөн<br>То- Анхдагч хавдар тодорхойлогдохгүй |

| | |
|---|---|
| | T1,T2,T3,T4-Анхдагч хавдрын тархалтыг тодорхойлно<br><br>**N- Хавдар орчмын тунгалгийн булчирхай**<br><br>No- Тунгалагийн булчирхайг гэмтээсэн шинж тэмдэггүй.<br><br>N1,N2, N3- Тунгалагийн булчирхайг хир зэрэг гэмтээснийг илэрхийлнэ.<br><br>Nx- Тунгалагийн булчирхай гэмтсэнийг тогтоох боломжгүй.<br><br>**M- Эрхтэнд үсэрхийлэлтэй эсэхийг харуулна**<br><br>Mo- Алсын эрхтэнд үсэрхийллийн шинж тэмдэггүй.<br><br>M1- Алсын эрхтэнд үсэрхийлэлтэй.<br><br>Mx- Алсын эрхтэнд үсэрхийлэл байгаа эсэхийг тогтоох боломжгүй. |
| Хавдрын төлөв | Эд, эсийн шинжилгээний дүгнэлтээс хавдрын эсийн төлөв байдлыг үндэслэн аль тохирохыг сонгон *√ * тэмдэглэгээ хийнэ. |
| Эсийн ялгарал | Эд, эсийн шинжилгээний дүгнэлтээс хавдрын эсийн ялгаралыг сонгон тохирохыг сонгон *√ * тэмдэглэгээ хийнэ. |
| Лимфома, лейкемийн эсийн ялгара | Цусны хавдруудын үед эсийн шинжилгээний дүгнэлтийг үндэслэн аль тохирохыг сонгон *√ * тэмдэглэгээ хийнэ. |
| Анхдагч олон байрлалын хавдар мөн эсэх | Анхдагч ганц байрлалын хавдар -1<br><br>Анхдагч олон байрлалын хавдрын нэг тохиолдол-2<br><br>Тодорхойгүй -9 тохирохыг сонгон *√ * тэмдэглэгээ хийнэ. |
| Хос эрхтэний хавдар мөн эсэх: | Баруун -1 Зүүн -2<br><br>Нэг талыг хамарсан боловч ялгаж тусгаагүй -3<br><br>Хоёр талыг хамарсан - 4<br><br>Хос эрхтэн бус -5 тохирохыг сонгон *√ * тэмдэглэгээ хийнэ. |
| Хавдрыг оношилсон шинжилгээ ба үндэслэл<br><br>/бичил харуурын бус, бичил харуурын / | Бичил харуурын болон бичил харуурын бус хүснэгтээс аль тохирохыг сонгон *√ * тэмдэглэгээ хийнэ .<br><br>**Анхаарах:** Бичил харуурын бус аргаас аль нэгийг сонгосон бол бичил харуурын аргаас сонгохгүй. Зөвхөн нэг л аргаас сонгоно. |
| Хавдрын эмнэл зүйн үе шат | I, II, III, IV гэсэн ромбо тоог ашиглан хавдрыг эмнэл зүйгээр нь үе шатаар ангилна. |

| | |
|---|---|
| Хийгдсэн эмчилгээ | Хавдрын онош батлагдсан үеэс эхлэн эхний курс эмчилгээний төлөвлөгөө болон хийсэн эмчилгээг эмчилгээний хүснэгтээс аль тохирохыг сонгон харгалзах тоог дугуйлна. |
| Хийгдсэн мэс заслын нэр, мэс засал хийсэн эмнэлэг, эмч | Мэс заслын нэрийг дэлгэрэнгүй гаргацтай тод бичнэ.<br><br>Мэс заслын үйлдлийн кодыг ӨОУА-IX-CM- Үйлдлийн Олон Улсын ангилал IX - III дугаар ботийг ашиглана. |
| Холбоо барих утасны дугаар | Өвчтөний өөрийн болон ар гэрийнхний 2-оос дээш дугаарыг бичнэ. |
| Мэдээлсэн огноо | АМ5-маягтыг хөтөлсөн он, сар өдрийг бичнэ. |
| Мэдээлсэн эмчийн нэр | Тухайн хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг мэдээлсэн их эмч нэр, албан тушаалаа тод гаргацтай бичиж гарын үсэг зурна. |
| Тамга | Мэдээлсэн эмч тамгаа дарсан байна. |

## 3. ХОРТ ХАВДРЫГ ЭМГЭГ СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИОС МЭДЭЭЛЭХ ХУУДАС

**А. ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛ:**

**1. Ургын овог:** ____________________________ **2.Эцэг /эхийн/ нэр:** _____________________

**3. Өөрийн нэр:**____________________________ **4. РД:** _________________________________

**5. Төрсөн:** _______ он _______ сар _____ өдөр **6. Нас:** ___ **7. Хүйс:** эрэгтэй [ 1], эмэгтэй [2 ]

**8.Тогтмол хаяг:** ____________________аймаг, хот______________________ сум, дүүрэг_______хороолол, _________________________ хороо, баг _______________ байр, тоот ______________________ утас

**А. ХАВДРЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ:**

1.**Сорьц илгээсэн эмнэлэг**:_____________тасаг _____________эмчийн нэр _____________

**2. Сорьц авсан эрхтэн:** __________________________________________________________

**Хос эрхтэн бол:** зүүн [ ] баруун [ ] хоёр тал [ ]

**3. Сорьцын төрөл:** хагалгааны материал эд [ ], арчдас [ ], анхдагч хавдрын эд [ ], Үсэрхийллийн эд [ ] , задлангийн эд [ ]

**4. Сорьцын шинжилгээний дүгнэлт:**___________________________________________

**5. Бүтэц зүйн онош:** _______________________________________________________

**6. Хавдрын төлөв:** [ ] хоргүй [ ] хортой [ ] байран өмөн [ ] мэдэхгүй

6. **Эсийн ялгарал:**өндөр ялгаралтай [ 1], дунд ялгаралтай [ 2 ], бага ялгаралтай [3], ялгаралгүй [4]

**В. МЭДЭЭНИЙ ЭХ СУРВАЛЖ:**

**1. Эмнэлгийн нэр:** ______________________________**3. Баримтын дугаар**: _____________

**2. Эмгэг судлалын лабораторийн нэр:** ____________________________________________

**4. Шинжилгээний дугаар:** ____________________________________________________

**Г. БҮРТГЭЛИЙН ХЭСЭГ:**

**1. Мэдээлсэн :** _______ он _______ сар _______ өдөр

**2. Мэдээлсэн мэргэжилтний нэр :** ___________________гарын үсэг __________________

холбоо барих утас:______________________

**3. Хүлээн авсан бүртгэлийн эмчийн нэр:** _________________________ гарын үсэг

**4. Хорт хавдрыг лабораториос мэдээлэх хуудас АМ-5-ЭС маягтыг хөтлөх зааварчилга**

Хорт хавдрыг эмгэг судлалын лабораториос мэдээлэх хуудсыг хагалгааны материал, задлан шинжилгээний дүгнэлтээс хорт хавдар оношлогдсон тохиолдолд эмгэг судлаач их эмч дараах зааварчилгааны дагуу хөтлөнө.

| Маягтын асуумж | Аргачлал-Тодорхойлолт - Жишээ |
|---|---|
| **I. Хувь хүний тухай мэдээлэл** | |
| Маягтын 1-3: | Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн тод гаргацтай, татлахгүйгээр үнэн зөв бичнэ |
| Өвчтний регистрийн дугаар РД: | Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ.<br>**Анхаарах зүйл:** РД гэсэн 10 нүд бүхий хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр дармалаар, сүүлийн 8 нүдэнд цифрийг нүд тус бүрт гаргацтай тод бичнэ.<br>А \| Ю \| 7 \| 8 \| 1 \| 2 \| 2 \| 9 \| 1 \| 3 |
| Төрсөн он сар өдөр | Төрсөн он, сар, өдрийг бичихдээ өвчтөний иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн бичнэ . Жишээ: 1978/12/29<br>**Анхаарах зүйл**: Төрсний гэрчилгээ аваагүй бол төрөлтийн түүхэн дэх төрсөн он, сар, өдрийг бичнэ. Төрсөн он, сарыг мэдэх боломжгүй тохиолдолд оныг мэдэж байвал сар, өдрийг 01 сарын 01-ээр авна. |
| Өвчтөний нас | Нас гэсэн нүд бүхий хүснэгтэд насыг бичихдээ төрсөн он, сарыг үндэслэн насыг тооцоолж бичнэ. Жишээ нь: насыг тооцоход 3 настай гэж гарсан бол гэж бичнэ. Хэрэв сар болон хоногтой бол нэгжийн оронг 0 болгож хүснэгтийн гадна сар, хоног аль нь болохыг бичнэ.<br>**Анхаарах зүйл**: Өвчтөний насыг мэдэх боломжгүй, нотлох бичиг баримт огт байхгүй бол - хорт хавдрын онош тавигдсан он, сар өдрөөр тооцоолно. |
| Хүйс | Эрэгтэй, Эмэгтэй аль болохыг сонгон *√ * тэмдэг тавина |
| Тогтмол хаяг | Өвчтөний иргэний үнэмлэхийг үндэслэн аймаг, хот, сум, дүүрэг, хороо, хаалганы дугаар зэргийг гаргацтай тод бичнэ. Харгалзах 6 нүд бүхий хүснэгтэд Эрүүл мэндийн сайдын 450 дугаар тушаалаар батлагдсан маягт бүртгэлийн эмхтгэл номын Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ангилал Хүснэгт №1-ийг ашиглан кодыг сонгон эхний 2 нүдэнд аймаг, хотын, дунд 2 нүдэнд сум, дүүргийн, сүүлийн 2 нүдэнд баг, хорооны кодыг бичнэ. |

| | |
|---|---|
| | Жишээ: Хөвсгөл аймгийн рашаант сум 1-р хороо гэсэн бол бичнэ. 1 7 1 1 0 1 |
| **II. ХАВДРЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ:** | |
| Сорьц илгээсэн эмнэлэг | Тухайн сорьцыг хийсэн эмнэлэг, тасгийн нэр, сорьцын шинжилгээ авсан эмчийн нэртэй тод гаргацтай бичнэ. |
| Сорьц авсан эрхтэн : | Тухайн сорьцыг авсан эрхтэнг бичнэ. Хэрвээ хос эрхтний аль нэг талаас сорьцийн шинжилгээ хийсэн бол аль талаас авсанаа чагтална. |
| Сорьцын төрөл | Сорьцын шинжилгээ нь хагалгааны материал эсвэл анхдагч хавдрын эд, үсэрхийллийн эд, задлангийн эд алинаас авагдсанг сонгоно. |
| Сорьцын шинжилгээний дүгнэлт | Эмгэг судлаач эмч сорьцын шинжилгээнээс гарсан дүгнэлтийг тод гаргацтай бичнэ. |
| Бүтэц зүйн онош | Сорьцын шинжилгээний дүгнэлтээс хавдрын эсийн төрөл, төлвийн байдлыг дэлгэрэнгүй бичиж, ОУӨА -ХС-III гарын авлагыг ашиглан дараах байдлаар дүгнэлтийг бичнэ. Жишээ нь:<br>1.Хавтгай эсийн;<br>2. Хавтга эсийн карцинома in situ;<br>3. Хавтгай эсийн карцинома, үсэрхийллийн;<br>4. Лимфома аль нь гарсан тохиолдолд дүгнэлтийг бичнэ. |
| Хавдрын төлөв | Эд, эсийн шинжилгээний дүгнэлтээс хавдрын эсийн төлөв байдлыг үндэслэн аль тохирохыг сонгон *√ * тэмдэглэгээ хийнэ. |
| Эсийн ялгарал | Эд, эсийн шинжилгээний дүгнэлтээс хавдрын эсийн ялгаралыг сонгон тохирохыг сонгон *√ * тэмдэглэгээ хийнэ. |
| **III. МЭДЭЭНИЙ ЭХ СУРВАЛЖ :** | |
| Хийгдсэн эмнэлэг | Сорьцын шинжилгээ хийсэн эмнэлгийн нэрийг бичнэ. |
| Баримтын дугаар: | Тухайн сорьцын шинжилгээ хийсэн дугаарыг бичнэ. |
| Эмгэг судлалын лабораторийн нэр | Эмгэг судлалын үндэсний төвийн аль эмнэлэг дээр байрлах тасгийн нэр бичнэ. |
| Шинжилгээний дугаар | Хийгдэж буй сорьцын шинжилгээний дугаарыг бичнэ. |

## 5. ХӨНГӨВЧЛӨХ ЭМЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТООН МЭДЭЭНИЙ ХУУДАС
**(Хорт хавдрын шалтгааны улмаас)**

| | Үзүүлэлт | Дэс дугаар | Өрхийн ЭМТ-д | Сум, тосгоны ЭМТ-д | Аймгийн нэгдсэн эмнэлэгт | Дүүргийн нэгдсэн эмнэлэгт | Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд | Хувийн эмнэлэгт | ХСҮТ-д | Хоспист |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | А | Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Нийт хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хамрагдсан хүний тоо мөр 1 = мөр ( 2+3+4) | 1 | | | | | | | | |
| Үүнээс | Гэрийн үзлэгээр | 2 | | | | | | | | |
| | Амбулаторийн үзлэгээр | 3 | | | | | | | | |
| | Стационараар | 4 | | | | | | | | |
| 2 | Өвдөлт намдаах эмчилгээнд хамрагдсан хүний тоо мөр 5 = мөр ( 6+7+8) | 5 | | | | | | | | |
| Үүнээс | Морфин тариа хэрэглэсэн хүний тоо | 6 | | | | | | | | |
| | Морфин ууж хэрэглэсэн хүний тоо | 7 | | | | | | | | |
| | Өвдөлт намдаах бусад эм/ тариа хэрэглэсэн хүний тоо | 8 | | | | | | | | |
| 3 | Шинж тэмдгийн эмчилгээ хийлгэсэн хүний тоо | 9 | | | | | | | | |
| 4 | Хөнгөвчлөх тусламж үзүүлдэг мэргэжилтний тоо | 10 | | | | | | | | |
| 5 | Хөнгөвчлөх тусламж үзүүлэх сайн дурын идэвхтнээр бэлтгэгдсэн хүний тоо | 11 | | | | | | | | |
| 6 | Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдсан хүний ар гэрээс сургалтанд хамрагдсан хүний тоо | 12 | | | | | | | | |
| 7 | Нэмэгдсэн орны тоо | 13 | | | | | | | | |
| 8 | Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо | 14 | | | | | | | | |

## 7. Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдсан хүний тоон мэдээний хуудас бөглөх зааварчилгаа

| Маягтын асуумж | Аргачлал |
|---|---|
| Нийт хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд хамрагдсан хүний тоо | Тухайн мэдээний хугацаанд хөнгөвчлөх тусламж үзүүлсэн нийт хүний тоо тавина. Энэ үзлэг нь гэрийн, амбулатороор, станционарын үзлэгийн нийлбэр |
| Гэрийн үзлэгээр | Тухайн мэдээний хугацаанд хэдэн удаа гэрийн эргэлтээр үзлэг хийсэн нийт тоо |
| Амбулаторийн үзлэгээр | Тухайн мэдээний хугацаанд хэдэн удаа амбулаторийн үзлэг хийсэн нийт тоо |
| Стационараар | Тухайн мэдээний хугацаанд хэдэн өвчтөн стационараар хэвтсэн нийт тоо |
| Өвдөлт намдаах эмчилгээнд хамрагдсан хүний тоо мөр 5 = мөр ( 6+7+8) | Тухайн мэдээний хугацаанд нийт өвдөлт намдаах эмчилгээ хийгдсэн хүний нийт тоог тавина. Энэ үзүүлэлт нь морфин тариагаар, уухаар, бусад өвдөлт намдаах эмжүүлэлтийн нийт тоон нийлбэр |
| Морфин тариа хэрэглэсэн хүний тоо | Тухайн мэдээний хугацаанд хэдэн удаа морфин тариа хэрэглэсэн нийт тоо |
| Морфин ууж хэрэглэсэн хүний тоо | Тухайн мэдээний хугацаанд хэдэн удаа морфин уухаар / 30 мг, 10 мг/ хэрэглэсэн нийт тоо |
| Өвдөлт намдаах бусад эм /тариа хэрэглэсэн хүний тоо | Тухайн мэдээний хугацаанд өвдөлт намдаах бусад эм /тариа хэрэглэсэн хүний нийт тоо<br><br>Жишээ нь. Фентацидин, Трамадол, кодейн эмийг / тариа, наалт гм-ээр /хэрэглэсэн тоо |
| Шинж тэмдгийн эмчилгээ хийлгэсэн хүний тоо | Зөвхөн шинж тэмдгийн эмчилгээ хийгдсэн хүний тоо |
| Хөнгөвчлөх тусламж үзүүлдэг мэргэжилтний тоо | Нутаг дэвсгэрийн хүрээнд нийт хэдэн мэргэжилтэн хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа мэргэжилтэний тоо . |
| Хөнгөвчлөх тусламж үзүүлэх сайн дурын идэвхтэн бэлдсэн хүний тоо | Нийт нутаг дэвсгэрийн хүрээнд хэдэн хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх сайн дурын идэвхтэн хэдэн удаагийн сургалтаар, хэдэн хүн бэлтгэсэн тоо |
| Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдсан хүний ар гэрээс сургалтад суусан хүний тоо | Нийт хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд хамрагдсан өвчтөний ар гэрээс өвчтөнг асрах талаар сургалтанд суусан хүний тоо |
| Нэмэгдсэн орны тоо | Тухайн улиралд эсвэл жилд нэмэгдсэн хөнгөвчлөх эмчилгээний орны тоо |
| Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо | Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний талаар сургалтанд суусан эмч, эмнэлгийн мэргэжилтэний тоо |

## 7. ХОРТ ХАВДРЫН ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ МЭДЭЭЛЭХ ХУУДАС

| **Ерөнхий бүлэг** | **Асуулт** | **Хариулт** |
|---|---|---|
| УДАМШЛЫН АСУУМЖ | Удамд хорт хавдраар өвчилсөн хүн бий эсэх | А. Тийм Б. Үгүй |
| ХАЛДВАРЫН АСУУМЖ | Элэгний вирусийн халдвартай эсэх | В вирус<br>А. Тийм Б. Үгүй<br>С вирус<br>А. Тийм Б. Үгүй<br>Д вирус<br>А. Тийм Б. Үгүй |
| | Хеликобактерийн халдвартай эсэх | А. Тийм Б. Үгүй |
| | Хүний хөхөнцөр вирусийн халдвартай эсэх | А. Тийм Б. Үгүй |
| ХОРТ ЗУРШЛЫН АСУУМЖ | Тамхи татдаг эсэх | А. Тийм Б. Үгүй |
| | Архи уудаг эсэх | А. Тийм Б. Үгүй |
| | Илүүдэл жинтэй байсан эсэх | А. Тийм Б. Үгүй |
| | Идэвхтэй хөдөлгөөнтэй байсан эсэх | А. Тийм Б. Үгүй |
| ОРЧНЫ БОЛОН АЖЛЫН БАЙРНЫ ХОРТОЙ НӨХЦӨЛ | Химийн хортой бодис хэрэглэдэг орчинд ажилладаг эсэх | А. Тийм Б. Үгүй |
| | Уул уурхайд ажилладаг эсэх | А. Тийм Б. Үгүй |
| | Химийн хортой бодис хэрэглэдэг үйлдвэрийн бүсэд амьдардаг эсэх | А. Тийм Б. Үгүй |
| | Уул уурхайн бүсэд амьдардаг эсэх | А. Тийм Б. Үгүй |
| ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ | Зөөврийн ус үндандаа хэрэглэдэг эсэх | А. Тийм Б. Үгүй |
| | Хүнсний ногоо тариалахдаа пестецид хэрэглэдэг эсэх | А. Тийм Б. Үгүй |

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 сарын
05 өдрийн 431 дугаар тушаалын
4 дүгээр хавсралт

**ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛЭГ, БҮРТГЭЛ-ТАНДАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТНИЙ АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ/загвар/**

**"А" Нийтлэг үндэслэл**

| Байгууллагын нэр | Нэгжийн нэр | |
|---|---|---|
| Аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төв | Халдварт бус өвчний тандалт, сэргийлэлтийн алба | |
| Ажлын байрны нэр | Ангилал | Зэрэглэл |
| Хорт хавдрын эрт илрүүлэг, бүртгэл-тандалтын мэргэжилтэн | Үндсэн мэргэжлийн ангилал, зэрэглэлийг баримтлана. | |
| Шууд харъялагдах ажлын байр (албан тушаал) | Шууд харъялах албан тушаал | |
| Албаны дарга, | | |

| | |
|---|---|
| Ажлын байрны зорилго | Харъяа орон нутгийн хорт хавдрын бүртгэл-тандалтын тогтолцоо болон эргэн дуудах тогтолцоонд хэрэглэгдэх маягтуудаар мэдээний сан үүсгэн, хүлээн авч сар, улирал, жилээр нэгтгэн мэдээний давхардлыг арилгах, тоолох, жилийн тайлан гаргах, эргэн мэдээлэх болон хорт хавдрын эрт илрүүлгийг зохион байгуулах, хяналт тавих |
| Ажлын байрны үндсэн чиг үүрэг | I. Хорт хавдрын бүртгэл- тандалтын тогтолцоо болон эргэн дуудах тогтолцооны үйл ажиллагаанд холбогдох бүртгэлийн маягтуудыг үнэн, зөв хөтлүүлэх, хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах, харъяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хорт хавдрын тохиолдлыг идэвхтэй хайх аргаар олж илрүүлэх, мэдээлэх;<br>II. Мэдээг нэгтгэх, мэдээний сан үүсгэх, мэдээний давхардлыг арилгах, тайлагнах;<br>III. Мэдээ, тайлан, мэдээний санг жилийн эцэст цэгцэлж архивлах, хадгалах;<br>IV. Хорт хавдрын эрт илрүүлгийг зохион байгуулах, хяналт тавих;<br>V. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцох;<br>VI. Мэдлэг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх. |

***"Б" Ажлын байрны гол үйл ажиллагаа***

| *Ажлын байрны гол үйл ажиллагаа:* | *Хугацаа хуваарь:* |
|---|---|
| <u>Ажлын байрны I үндсэн зорилтын хүрээнд</u>:<br>- Хорт хавдрын бүртгэл-тандалтын тогтолцоо болон эргэн дуудах тогтолцооны анхан шатны маягтын хангалт, маягтуудыг асуумжийн дагуу үнэн, зөв хөтөлсөн байдалд хяналт тавих, маягт, тоотыг зөв тоотлосон эсэхийг шалгах, эргэн мэдээлэл хийх;<br>- Харъяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллага, шүүх эмнэлэг, эмгэг судлалын хэлтсээс хорт хавдрын шинэ тохиолдлыг идэвхтэй хайх аргаар олж илрүүлэх; | |

| | |
|---|---|
| - Харъяа орон нутгийн иргэний бүртгэлийн газартай жилийг эцэст нэг удаа хорт хавдрын хяналтын бааз мэдээг тулгалт хийн мэдээний санг баяжуулах;<br>- Зөрчил, алдаа гарсан тохиолдолд арилгуулах, арга зүйн зөвлөмжөөр хангах. | Тогтмол |
| Ажлын байрны II үндсэн зорилтын хүрээнд:<br><br>- Хорт хавдрын бүртгэл-тандалтын тогтолцоо болон эргэн дуудах тогтолцооны мэдээг сар, улирлаар хүлээн авах, нэгтгэх, мэдээний санг үүсгэх;<br>- Тайланг батлагдсан маягт, аргачлалын дагуу хугацаанд нь гаргаж нэгтгэн холбогдох эрүүл мэндийн байгууллагад өгөх;<br>- Хорт хавдрын бүртгэл- тандалтын тогтолцоо болон эргэн дуудах тогтолцооны цахим мэдээний санг сар, улиралд цахим хэлбэрээр хүлээн авах, нэгтгэх, давхардлыг арилгах, мэдээний санг шалгах;<br>- Хорт хавдрын улмаас эмнэлэгт болон эмнэлгийн бус газар нас барагсдын бүртгэлийг нэгтгэн давхардлыг арилган, мэдээг магадлан мэдээлэх;<br>- Мэргэжил арга зүйгээр хангах, шаардлагатай арга хэмжээ авах талаар санал гаргах;<br>- Холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад эргэн мэдээлэх. | |
| Ажлын байрны III үндсэн зорилтын хүрээнд:<br><br>- Хорт хавдрын бүртгэл-тандалтын тогтолцоо болон эргэн дуудах тогтолцооны удирдамжид заасны дагуу мэдээний санг архивлах;<br>- Өөрийн ажлын холбогдолтой судалгааны ажилд оролцох;<br>- Төлөвлөх, бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшний удирдлагууд болон мэдээлэл хэрэглэгчдээс шаардсан мэдээ, мэдээллийг үнэн зөв, шуурхай гаргаж өгөх. | |
| Ажлын байрны IV үндсэн зорилтын хүрээнд:<br><br>- Зонхилон тохиолдох хорт хавдрын эрт илрүүлгийг зохион байгуулах;<br>- Зохион байгуулалтын арга зүйгээр хангах;<br>- Хорт хавдрын эрт илрүүлгийн чанар, хүртээмжийг сайжруулах;<br>- Эрт илрүүлэгт хяналт тавих;<br>- Эрт илрүүлэгт оролцогч бйагуулагуудын ажлын уялдааг хангах, зохицуулах. | |
| Ажлын байрны V үндсэн зорилтын хүрээнд:<br><br>- Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, стандарт болон холбогдох зааврыг мөрдөж ажиллах. | |
| Ажлын байрны V/ үндсэн зорилтын хүрээнд:<br><br>- Багц цагаа биелүүлэхийн тулд идэвх санаачлага гаргах;<br>- Байгууллагаас зохион байгуулж буй сургалтанд оролцох. | |

**В.Тавигдах шаардлага**

| 1.Ажлын байранд | 1.1 Ерөнхий шаардлагууд | Үзүүлэлт | Зайлшгүй шаардлагатай | Шаардлага-тай |
|---|---|---|---|---|
| | | Боловсрол | Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, бага эмч, статистикч их, бага эмч, сувилагч-Баклавр зэрэгтэй сувилагч | - |
| | | Мэргэжил | Нийгмийн эрүүл мэнд, биостатистик чиглэлээр мэргэшсэн байж болно. | - |

| | | | |
|---|---|---|---|
| | Мэргэшил | Хорт хавдрын эрт илрүүлэг, бүртгэл-тандалтын мэргэжилтэн | - |
| | Туршлага | Нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн статистик, тархвар судлал, хавдрын чиглэлээр ажиллаж байсан | - |
| | Нэмэлт ур чадвар | - Багаар ажиллах;<br>- Харьцааны чадвар;<br>- Компьютерын программ ашиглах чавдар;<br>- Судалгааны арга зүйн мэдлэгтэй;<br>- Мэдээ , мэдээллийг тооцоолох, дүн шинжилгээ хийх ур чадвар;<br>- Мэргэжлийн ном товхимлыг гадаад хэл дээр ашиглах чадвар. | - |
| 1.2.Тусгай шаардлага: | | - Ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллах;<br>- Үйл ажиллагаагаа Авилгын эсрэг хуулийн хүрээнд явуулж, авилгаас ангид байх. | |

**“Г”. Хүчин зүйлс**

| | | |
|---|---|---|
| 1. Ажлын байрны харилцах субъект | | |
| 1.1.Байгууллагын дотор талд байгаа:<br><br>- Төвийн алба, хэлтсийн дарга;<br>- Албаны бусад ажилтнууд;<br>- Бусад эмч, сувилагч. | | 1.2. Байгууллагын гадна талд байгаа:<br><br>- ЭМХТ-СМА;<br>- ХСҮТ-ийн НЭМЭШС-ын Алба;<br>- Анагаах ухааны боловсрол олгодог сургууль<br>- Өрх,сум, тосгоны эрүүл мэндийн төв;<br>- Нэгдсэн эмнэлэг, БОЭТ<br>- Иргэний бүртгэл мэдээллийн төв;<br>- Төрийн болон төрийн бус байгууллага. |
| 2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага | Хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, эмчийн ёс зүйн дүрэм, бусад хууль тогтоомж болон ажлын байрны үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагаатай холбоотой асуудлыг байгууллагын захиргааны өмнө хариуцна. | |
| 3. Ажлын байрны нөөц хэрэгсэл | 3.1.Санхүүгийн: Цалин (ТҮЭМ- 5) | -Харилцаа хандлагын нэмэгдэл;<br>-Хоол, унаа;<br>-Холбогдох хууль тогтоомжийн дагуух бусад нэмэгдэл (зэргийн нэмэгдэл г.м) |
| | 3.2.Материалын | - Эрүүл ахуйн шаардлага хангасан өрөө тавилга;<br>- Ажлын хувцас (2 удаагийн);<br>- Хамгаалах хэрэгсэл;<br>- Бичгийн хэрэгсэл;<br>- Компьютер (интернетэд холбогдсон),<br>- Бүртгэл-тандалтын программ хангамж<br>- Принтер, цаас<br>- Телефон утас. |
| | 3.3.Хүний | - |
| | 3.4.Бусад | Жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдах |

| | | |
|---|---|---|
| 4. | Ажлын байрны нөхцөл | Хэвийн |
| 5. | Орлох, хавсарч ажиллах ажлын байрны нэр | |

**“Д”. Баталгаажуулалт**

| Ажлын байрны тодорхойлолтыг баталсан | Ажлын байрны тодорхойлолтыг баталсан | Ажлын байрны тодорхойлолттой танилцаж, зөвшөөрсөн |
|---|---|---|
| Аймаг, дүүргийн НЭМТийн дарга<br>______________________<br>___оны _ сарын __-ны өдөр | Албаны дарга<br>______________________<br>__оны __ сарын __-ны өдөр | Хорт хавдрын эрт илрүүлэг, бүртгэл-тандалтын мэргэжилтэн<br>______________________<br>___оны __ сарын __-ны өдөр |